

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА, ТӨРИЙН
ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2024 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/19, А/16

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм"-ийн 4.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн болон төрийн өмчийг менежментийн гэрээгээр ашиглаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын газар болон үл хөдлөх бусад хөрөнгийн ашиглалтын байдалд хамтарсан хяналт шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Түвшинзаяа

(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)

Гишүүд: Ц.Мөнх-Эрдэнэ

(Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн хянан шалгагч, ахлах шинжээч)

Д.Мөнхтуяа

(Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн хянан шалгагч, ахлах шинжээч)

Д.Нарангэрэл

(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)

Д.Сувдмаа	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)
Э.Ганчимэг	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)
А.Алтаншагай	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)
Ч.Батчимэг	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч)
М.Баярцэцэг	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч)
Г.Дэлгэрмаа	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)
Л.Гэрэлмаа	(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч)

Нарийн
бичгийн дарга: Д.Оюунгэрэл

(Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

Төрийн өмчийн хяналт
шалгалтын хэлтсийн
мэргэжилтэн)

2.Хяналт шалгалтад "Их дээд сургуулийн хөрөнгийн менежментийн төв" ТӨҮГ, Орон нутгийн өмчийн газар, Их дээд сургуулиудын дотоод хяналтын нэгжийг татан оролцуулахыг Ажлын хэсгийн дарга /Ц.Түвшинзаяа/-д зөвшөөрсүгэй.

3.Хяналт шалгалтад хамрагдах төрийн өмчийн болон төрийн өмчийг менежментийн гэрээгээр ашиглаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын жагсаалтыг 1 дүгээр, Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Хяналт шалгалтад шаардлагатай баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн гаргаж өгөхийг энэ тушаалын 1 дүгээр хавсралтад заасан их, дээд сургуулийн удирдлагад үүрэг болгосугай.

5.Хяналт шалгалтыг 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс мөн оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд гүйцэтгэж, дүнг 2024 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Түвшинзаяа/-т даалгасугай.

6.Хяналт шалгалтын хүрээнд албан томилолтоор ажиллах болон холбогдох бусад зардлыг тухайн хяналт шалгалт хэрэгжүүлэгч байгууллагуудад тус тус хариуцуулсугай.


ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Б.БААСАНДОРЖ

9023010230 CTC3850 6275747

ТӨРИЙН ӨМЧИЙН
БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 3 дугаар сарын 27 ны өдрийн 1/3, 1/6 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

9023910230 CTC3950 9075747

ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХАМРАГДАХ СУРГУУЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Сургууль
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
2	Дархан хот дахь салбар сургууль
3	Дорноговь аймаг дахь салбар сургууль
4	Говь-Алтай аймаг дахь салбар сургууль
5	Монгол Улсын Их сургууль
6	Ховд аймаг дахь салбар сургууль
7	Дорнод аймаг дахь салбар сургууль
8	Завхан аймаг дахь салбар сургууль
9	Монгол Улсын Боловсролын их сургууль
10	Архангай аймаг дахь салбар сургууль
11	Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль
12	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
13	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль
14	"Эрдэнэт" цогцолбор дээд сургууль
15	Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль
16	Технологийн коллеж
17	Хөдөө аж ахуйн их сургууль
18	Дархан хот дахь салбар сургууль
19	Баянхонгор аймаг дахь салбар сургууль
20	Соёл урлагийн их сургууль
21	Монгол Улсын Консерватор
22	Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллеж
23	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль
24	Дотоод хэргийн их сургууль
25	Удирдлагын академи
26	Үндэсний тагнуулын академи
27	Төмөр замын дээд сургууль
28	Үндэсний батлан хамгаалахын их сургууль
29	Хүмүүнлэгийн ухааны их сургууль
30	Санхүү, эдийн засгийн их сургууль



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хяналт шалгалт хийх үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 5 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалт.

1.2.Хяналт шалгалт зорилго: Төрийн өмчийн болон төрийн өмчийг менежментийн гэрээгээр ашиглаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын газар болон үл хөдлөх бусад хөрөнгийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж дүнг танилцуулахад оршино.

1.3. Хяналт шалгалт хамрагдах төрийн өмчит хуулийн этгээдийн нэр: Төрийн өмчийн болон төрийн өмчийг менежментийн гэрээгээр ашиглаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагууд.

1.4.Хяналт шалгалт хийх хугацаа: 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

1.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь хяналт, шалгалтын ажлын хэсгийг шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангаж, холбогдох ажилтнуудыг шаардлагатай тайлан мэдээ, санхүүгийн болон бусад баримт материалын хамт шаардсан хугацаанд бэлэн байлгах, холбогдох программ хангамжид нэвтрэх зэрэг шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангана.

1.6.Хяналт шалгалтад хамрагдах сургалтын байгууллага нь шалгалтын хугацаанд Ажлын хэсэгт шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

Хоёр.Хяналт шалгалт хийх чиглэл

2.Хяналт шалгалтыг дараах чиглэлийн хүрээнд явуулна:

2.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлага, үйл ажиллагааны талаар

2.1.1. Хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, дүрэм;

2.1.2. Хуулийн этгээдийн гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, бусад эрхийн акт үл хөдлөх хөрөнгийн талаар гарсан Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт;

2.1.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах дээд байгууллага, төрийн өмчийн талаар олгосон бүрэн эрх, гарсан шийдвэр, холбоотой захирлын тушаал шийдвэр, эрх зүйн акт;

2.1.4. Дотоод хяналтын үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн хяналт шалгалт /Төрийн өмчийн газар, эд хөрөнгийн чиглэлээр/;

2.1.5.Төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгөд аудитын болон бусад дээд шатны байгууллага, дотоод хяналтын нэгжээс хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, тавьсан акт, албан шаардлага, өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилт.

2.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмших/ашиглах эрхийн газрын асуудлаар:

2.2.1.Газар эзэмших, ашиглах эрхийн баталгаажуулалт /гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг/, түүний бүртгэл хөтлөлт, тооллого үр дүн;

2.2.2.Газар эзэмших ашиглах эрхийн хэмжилт баталгаажуулалт, зориулалт, ашиглалтын байдал;

2.2.3.Газрын үнэлгээ, санхүүгийн тайлан тэнцэлд туссан байдал, газрын төлбөр тооцоо барагдуулалт;

2.2.4.Эзэмших/ашиглах эрхийн газрын хэмжээ, байршил, үнэлгээ, эзэмшил, ашиглалтын маргаантай асуудал байгаа эсэх, байгаа бол нөхцөл шалтгааныг тодруулах;

2.2.5.Эзэмших/ашиглах газарт хамаарах үл хөдлөх хөрөнгө, тэдгээрийн ашиглалтын байдлыг биет үзлэг хийх замаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, /шаардлагатай тохиолдолд Улсын үзлэг тооллогын материалаас хөөн шалгах/.

2.3.Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн асуудлаар:

2.3.1.Үл хөдлөх хөрөнгүүд тэдгээрийн суурилагдсан хүчин чадал, зориулалт, үнэ, дахин үнэлгээ, хөрөнгийн ашиглалт, шинэчлэлтийн байдал,

хөрөнгө оруулалт түүний үр өгөөж, элэгдэл тооцсон жил, насжилтын судалгааг гаргаж дүн шинжилгээ хийх;

2.3.2.Улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, хандив, зээл тусламжийн эх үүсвэрээр бэлтгэсэн дуусаагүй барилга, үл хөдлөх хөрөнгийн судалгааг гаргах, нөхцөл шалтгааныг тодруулах, дүн шинжилгээ хийх;

2.3.3.Үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээнд хамруулсан байдал, хөрөнгийн бодит үнэ цэнэ, насжилтад гарсан өөрчлөлт, үр дүнгийн талаар;

2.3.4.Үл хөдлөх хөрөнгийн доорх эзэмшил газрыг баталгаажуулсан байдал, баталгаажуулаагүй бол нөхцөл шалтгааныг тодруулан, тайлбар гаргуулах;

2.3.5.Үл хөдлөх хөрөнгөд барилгын хувийн хэрэг хөтөлж баяжуулалт хийсэн байдал, их засвар, хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд нь хийж, бүртгэлд тусгасан эсэх;

2.3.6.Үл хөдлөх хөрөнгийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн маргаан байгаа эсэх, байгаа бол нөхцөл шалтгааныг тодруулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах;

2.3.7.Үл хөдлөх хөрөнгийг бусад төрийн болон хувийн өмчийн байгууллагад үнэ төлбөргүй, түрээсийн журмаар, ашиглалтын зардлаар, бусад аж ахуйн зориулалтаар ашиглуулж байгаа эсэх энэхүү үйл ажиллагаагаа нь хууль тогтоомжид нийцсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

2.3.8.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2021 оны Улсын үзлэг тооллогын дүн, тооллогоор газар, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой илэрсэн зөрчил дутагдал, авсан арга хэмжээний талаар;

2.3.9.Газар, үл хөдлөх хөрөнгө тэдгээрийн ашиглалтын байдлыг фото зураг болон бусад холбогдох зургаар баталгаажуулан тайланд хавсаргасан байна.

2.3.10.Үл хөдлөх хөрөнгөд хамаарах бусад хөрөнгө /Нийтийн эзэмшлийн хөрөнгө/-ийн талаар судалгаа гаргаж холбогдох хууль эрхзүйн актуудтай уялдуулан шалгах, шаардлагатай зөвлөмж дүгнэлтийг гаргах.

Гурав.Хяналт шалгалт хийх зохион байгуулалт, арга хэлбэр

3.1.Хяналт шалгалтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

3.1.1.удирдамжид заасан чиглэл, агуулга тус бүрээр хяналт шалгалт хийх;

3.1.2.шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг гаргуулан авах;

3.1.3. хяналт шалгалтыг баримт бичиг судлах, асуулга авах, тандан судлах, цахим систем ашиглах, биечлэн уулзах, үйл ажиллагаатай танилцах, ярилцлага хийх, мэдээлэл авах зэрэг байдлаар хэрэгжүүлэх;

3.1.4. бусад.

Дөрөв. Шалгалтын дүн гаргах, тайлагнах

4.1. Шалгалтын ажлын хэсэг шалгалтыг батлагдсан удирдамж, хуваарь, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хийж, заасан хугацаанд Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад бүрэн хүлээлгэж өгнө.

4.2. Ажил үүргийн хуваарийн дагуу ажлаа гүйцэтгээгүй бол хариуцлагыг холбогдох албан хаагч хариуцна.

4.3. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга шалгалтын явцын тайланг авч нэгтгэн Ажлын хэсгийн даргыг мэдээллээр хангах үүрэгтэй.

4.4. Хяналт шалгалтын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийн нууцлалыг хадгална.

4.5. Удирдамжийн дагуу боловсруулсан шалгалтын тайлан, цаашид авах арга хэмжээний талаар гаргасан санал, дүгнэлтийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэж дүнг Ажлын хэсгийн даргад танилцуулна.

---oOo---